



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2017. 05. 05 № 07

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЖАРГАЛТУЛГЫН ЭРДЭНЭБАТ ТАНАА**

Асуулга тавих тухай

Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах зохистой менежментийг хэрэгжүүлэх, ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар хот, суурин газрын ногоон байгууламж зохистой хэмжээнээс 10 дахин бага байна гэсэн судалгаа гарсан байна. Энэ байдал нь хотын ногоон байгууламж, цэцэрлэгжсэн талбай нь хүн амын хүчилтөрөгчийн хангамж, цэвэр агаар хүлээн авах боломжит нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс өөр шинээр хотын чанартай томоохон ногоон байгууламж барьж байгуулагдаагүй байна.

Дээрх нөхцөл байдал нь манай орны эко бүтэц түүний дотор ногоон орчны хөгжил туйлын хангалтгүй байгааг харуулж байгаа юм.

Иймээс Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дор дурьдсан асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Нийслэл, аймаг, суурин газрын ногоон бүсийг нэмэгдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны талаар

2. Энэ асуулгын тодорхой жишээ болгон нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах “Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн”-гийн асуудлаар хариу ирүүлнэ үү. Тус цэцэрлэгт хүрээлэнгийн газарт хууль бусаар барилгын ажил явагдах болсон тул цэцэрлэгт хүрээлэнг “Зүүн бүсийн соёл амралтын хүрээлэн” болгон ногоон байгууламжаар үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн явуулах нь зүйтэй байна. Иймд “Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн”-ийн харьяалал, газрын эзэмшлийн асуудал, ногоон байгууламжийн газарт барилга барих болсон зэрэг асуудлын талаар

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд албан бичгээр ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсч байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН**

Б.САРАНЧИМЭГ

